

**ХЭНТИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
АЛБАН ХААГЧДЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГ
ҮНЭЛСЭН ТУХАЙ ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ИЛТГЭХ ХУУДАС**

2025 оны 11 дүгээр сарын 28.

Чингис хот

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн тоот албан бичгийн дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/13 дугаар тушаалаар "Үнэлгээний баг"-ийг захигааны ахлах мэргэжилтэн С.Саранцэцэг, иргэний бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ш.Мөнхзул, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Ц.Соёл-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй томилж, "Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлал", зөвлөмжийн дагуу гүйцэтгэлийн тайланг үнэлэх ажиллагааг зохион байгууллаа.

Төрийн захиргааны 31 албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт ирүүлсэн байна.

Үнэлгээний баг нь нэгжийн дарга нарын үнэлсэн албан хаагчийн төлөвлөгөөний биелэлтийг нэг бүрчлэн үзэж, "Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх аргачлал-ын дагуу үнэн бодитой үнэлсэн эсэхэд хяналт тавьсан ба нэгжийн даргын үнэлсэн үнэлгээг бодитой гэж үзлээ.

Нэгжийн дарга албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлж, албан хаагч бүрт танилцуулж ажилласан ба үнэлгээтэй холбоотой гомдол санал үнэлгээний багт ирээгүй болно.

Төрийн үйлчилгээний ажилтнуудын ажлын үр дүнг удирдлагуудын саналаар шийдвэрлэнэ.

Үнэлгээний баг төрийн захиргааны албан хаагчдын 2025 оны эхний хагас жилийн үр дүнг үнэлэхэд үнэлгээний нэгдсэн жагсаалтад "Маш сайн" 17, "Хэвийн" 13, "Хангалтгүй" 1 албан хаагч тус тус дүгнэгдлээ.

Тус хэлтсийн төрийн жинхэнэ албан хаагчдын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн үнэлгээг мэдээлэх хуудас, үнэлгээний нэгдсэн жагсаалтыг хавсаргаж хүргүүлэв.

ХЯНАСАН:

ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН АХЛАГЧ

 С.САРАНЦЭЦЭГ

ТАНИЛЦСАН:

ГИШҮҮД



Ш.МӨНХЗУЛ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧИГ



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ